

НЭГ.НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Төсөл хэрэгжих талбай нь Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын нутагт байрлах бөгөөд энэ бүлэгт аймаг болон сумын хэмжээнд нийгэм эдийн засгийн өнөөгийн төлөв байдлыг тодорхойлов. Нийгэм эдийн засгийн судалгааны тайланг боловсруулахдаа Баянхонгор аймгийн цахим хуудас болон Баянхонгор аймгийн статистик мэдээллийг ашиглав.

1.1.НУТАГ ДЭВСГЭР, ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ

Баянхонгор аймгийн Баян-Овоо сум нь 1946 онд байгуулагдсан. Нийт газар нутгийн хэмжээ 324449 га эзлэн оршдог. Мандалхайрхан, Уранхайрхан, Асгамба, Хөхбүрд гэсэн 4 багтай. Баянхонгор аймгийн Галуут, Эрдэнэцогт, Бөмбөгөр, Баацагаан, Жинст, Өлзийт гэсэн сумдтай хиллэдэг. Улаанбаатраас 646 км, аймгийн төвөөсөө 26 км зайд байрладаг.

Баян-Овоо сумын нийт газар нутгийн хэмжээ 324449 га юм. Үүнээс 99.3% нь хөдөө аж ахуйн зориулалт бүхий газар, 0.2% ойн сан бүхий газар, 0.5 га усан сан бүхий газар байна.



Зураг 3-1. Баянхонгор аймгийн Баян-Овоо сум

1.2.ОРОН НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвөөс бүрдэнэ. Орон нутгийн төсөв орлого нь татварын орлого, татварын бус орлого, бусад орлогоос бүрдэнэ. Баянхонгор аймгийн төсвийн орлого зарлагын хэмжээг 2016-2020 он тус бүрийн жилийн эцсийн байдлаар График 3-1-т харуулав. Үүнээс харвал Баянхонгор аймгийн төсвийн орлогын хэмжээ 2016-2020 онуудад тогтмол өсөлттэй байсан байна. Мөн 2016-2020 онуудад аймгийн төсвийн зарлагын хэмжээ орлогын хэмжээнээс тогтмол бага үзүүлэл



График 3-1. Баянхонгор аймгийн төсвийн орлого, зарлагын харьцаа, сая.₮ (2016-2020 он)

1.1 ХҮН АМ, АЙЛ ӨРХ

Хүн ам, хүйсийн байдал

Баян-Овоо сумын хүн ам 2017 онд 2673 байсан бол 2021 оны 2-р улирлын байдлаар 2613 болж буурсан бол 2025 оны жилийн эцсийн байдлаар 2363 болж ... хувиар буурсан. Энэ нь сумын хүн амын тоо 2021-2025 оны 12 дугаар сарын байдлаар ... хувиар буурсан үзүүлэлт юм.

Эдгээр онууд дахь Баян-Овоо сумын хүн амын хүйсийн бүтцийг харвал 2017-2021.ИI улиралд хүн амын тоо жигд, хүйсийн харьцаа эрэгтэй илүү байна. Тухайлбал: 2021 оны 2-р улирлын хувьд сумын нийт хүн амын 52.2 (1365) хувийг эрэгтэй, 47.7 (1248) хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Баян- Овоо сумын хүн амын тоо, хүйсийн харьцааг График 3-2-т харууллаа




График 3-2. Баян-Овоо сумын хүн амын тоо, хүйсээр (2017-2021.II улирал)

Өрхийн тоо

Баянхонгор аймаг нь 2020 оны байдлаар 25999 өрхтэй үүнээс Баян-Овоо сум 673 өрхтэй буюу аймгийн хэмжээнд өрхийн 2.5 %-ийг бүрдүүлдэг байна.

Баян-Овоо сум дахь өрхийн тоо 2023-2025 оны хооронд 873-аас 673 болж 200-аар буурсан байна. Энэ нь өрхийн тоо нь **2022** оноос хойш 22 хувь буурсан үзүүлэлт юм (Хүснэгт 3-1).

Хүснэгт 3-1. Баян-Овоо суман дахь өрхийн тоо, 2022-2025

Он	2023	2024	2025
Өрхийн тоо	873	734	673

2.5. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Энэ хэсэгт Баянхонгор аймгийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, шинээр бий болсон ажлын байр, ажил хайгч иргэн, байнгын болон түр ажлын бар зэрэг мэдээллийг оруулсан.

Ажиллагсад 2024 онд нийт 42,983, байнгын ажлын байранд 645 иргэн, түр ажлын байранд 1275 иргэн ажиллаж байна. Шинээр бий болсон ажлын байранд 829 иргэн, улиралын ажлын байранд 37 иргэн ажлын байраар хангагдсан байна. 2025 онд 39,902 болж буурсан байна. Мөн шинээр бий болсон ажлын байран дээр 829 иргэн ажиллаж байна.

2025 онд тус аймгийн хэмжээнд 45,800 мянган ажиллах хүч байгаагийн 93,8% буюу 42,9 мянга нь ажиллагчид, 6,6% буюу 2,7 мянган хүн нь ажил идэвхтэй ажил идэвхтэй эрж хайж байгаа ажилгүй иргэд байна.

Өмнөх оноос ажиллагчдын тоо 11,8%-иар нэмэгдсэн, ажиллах хүчний оролцооны түвшин 71%, ажилгүйдлийн түвшин 6,1% байна.

Салбар	2024	2025
Ажиллах хүч	45,794	41,544
Ажиллагчид	42,983	39,902
Ажилгүй хүн		1,642
	2,811	
Ажиллах хүчний оролцооны түвшин	71	68,4
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	66,6%	65,8%
Ажилгүйдлийн түвшин	6,1%	6,4%
Залуучуудын ажилгүйдлийн түвшин	10,2	6,8
Ажиллагсдын дундаж цалин	1,906,8	2,359,1
Ажил хайгч иргэн	863	176
Бүртгэлтэй ажилгүй иргэн	767	144
Ажлын байрны захиалгын тоо	2,706	1,242
Байнгын ажлын орсон иргэд	829	580
Улирлын ажлын байранд орсон иргэн	37	284
Түр ажлын байранд орсон иргэн	829	72
Нийт		

Нийт ажилагсдын 51,8% нь хөдөө аж ахуйн салбарт, 14,0% нь боловсролын салбарт, 9,4% нь төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарт 7,6%, уул уурхайн, олборлолтын салбарт 4,7% худалдааны салбарт ажиллаж байна.

2024 онд аж ахуйн нэгж байгууллагын ажиллагчдын сарын цалин 1,906,8 мянган төгрөгт хүрч, өмнөх оноос 40,9% буюу 553,600 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 3-2. Баянхонгор аймаг дахь ажиллагсдын тоо, эдийн засгийн салбараар

Ажил хайгч иргэдийн тоо, боловсролын түвшин

Баянхонгор аймагт 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 45,800 ажиллах хүч байгаагийн 43,000 ажилагсад, 2811 ажилгүй иргэдээс 1642 нь бүртгэлтэй ажил хайгч буюу 58,4% байна.

сарын байдлаар 941 иргэн ажил хайгчаар бүртгэгдсэн байгаа бөгөөд тэдгээрийг боловсролын зэргээр нь авч үзвэл нийт ажил хайгч иргэдийн 44,5 хувь нь бүрэн дунд, 25 хувь нь дипломын болон бакалаврын, 8,8 хувь нь техникийн болон мэргэжлийн, 3,5 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 10,8 хувь нь суурь, 4,8 хувь нь бага, 1,7 хувь нь боловсролгүй ажил хайгч иргэд байна (График 3-3)




График 3-3. Баянхонгор аймгийн ажил хайгч иргэдийн боловсролын түвшин өөрчлөөгүй

3.2.1 Боловсрол

Сургуулийн өмнөх боловсрол

Баян-Овоо суманд 1 цэцэрлэг үйл ажиллагаагаа явуулж байна. Цэцэрлэгт хамрагдсан нийт хүүдийн тоо 2018 онд 133 хүүхэд, 2019 онд 130, 2020 онд 95, 2024 онд 158, 2025 онд 184, 2026 онд 174 сурагч бүртгэлтэй байна. /Энэ тоон мэдээлэлд явуулын бүлэг, нүүдлийн бүлгийн хүүхдүүдийн тоо орсон./

Харин сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллагсдын тоо ч 2024 онд 16 байсан бол 2025 онд 18, 2026 оны 2 дугаар улирлын байдлаар 20 ажилтантай бол өссөн байна. (Хүснэгт 3-3).

Үзүүлэлт	2024	2025	2026
Цэцэрлэгийн тоо	1	1	1
Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхэд	158	170	174
Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын ажиллагсад:	16	18	20
Үнд			
Үндсэн багш	4	4	4
Туслах багш	4	4	4
Бусад ажиллагчид	8	10	12

Хүснэгт 3-3. Баян-Овоо сумын сургуулийн өмнөх боловсролын үзүүлэлт

Ерөнхий боловсрол

Сумын хэмжээгээр 2024-2026 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 1 сургууль үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нэг дүгээр ангид шинээр элсэгчдийн тоо 2024 онд 20 байсан бол 2019 онд 24, 2020 онд 29 болж бага хэмжээгээр нэмэгдсэн байна. Харин ерөнхий боловсролын сургуульд суралцагсдын нийт тоо 2018 оны 133 байсан бол 2019 онд 170, 2020 онд 196 болж өссөн. Түүнчлэн, сумын хэмжээнд ЕБС-д багшилдаг үндсэн багшийн тоо 2018-2020 онд 12-өөс 3 болж буурсан байна (

Хүснэгт 3-4).

Үзүүлэлт	2024	2025	2026
Ерөнхий боловсролын сургуулийн тоо	1	1	1
ЕБС-ийн нэгдүгээр ангид шинээр элсэгчдийн тоо	21	24	29
Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчдын тоо	133	170	196
Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш	13	13	13

Хүснэгт 3-4. Баян-Овоо сумын ерөнхий боловсролын үзүүлэлтүүд

Эрүүл мэнд

Баян-Овоо сум нь нэгдсэн 1 эрүүл мэндийн төвтэй ба 2026 оны байдлаар 1 их эмч, 6 сувилагч, 1 эх баригч эмч, 3 багийн эмч, 1 лаборант, 1 эм найруулагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Сүүлийн 5 жилийн байдлаар эм найруулагчийн орон тоо шинээр нэмэгдсэн байна.

Ажилчид	2023	2024	2025	2026
Их эмчийн тоо	1	1	1	1
Сувилагч	5	5	6	6
Эх баригч	1	1	1	1
Багийн эмч	3	3	1	2
Лаборант	1	1	1	1
Эм найруулагч	0	1	1	0

Хүснэгт 3-5. Эрүүл мэндийн байгууллагын ажиллах хүч

2016-2021 оны байдлаар тус суманд нийт нас баралт 50 байгаа бол нас баралтын гол шалтгаан нь зүрх судасны өвчлөл байна.




График 3-4. Баян-Овоо сумын иргэдийн нас баралтын шалтгаан, 2020 он

Түүнчлэн тус сумын хэмжээнд 2016-2020 оны хооронд нийт 6 эх амаржсан бол дээрх онуудад эхийн эндэгдэл болон нярайн эндэгдэл байхгүй байна.

Хүснэгт 3-6. Эх, нярайн эндэгдэл, 2016-2020

	2016	2017	2018	2019	2020
Эхийн эндэгдэл	0	0	0	0	0
Нярайн эндэгдэл	0	0	0	0	0
Амаржсан эх	2	1	1	0	2

Харин халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 2019 онд хамгийн их байсан байна. Халдварт өвчлөлийн нийт дүнгээр салхин цэцэгээр иргэд хамгийн их өвчилдөг бол вируст гепатитээр иргэд хамгийн бага буюу сүүлийн таван жилийн хэмжээнд ердөө ганц хүн өвчилсөн байна.

Хүснэгт 3-7. Халдварт өвчнөөр өвчлөгчид, 2016-2020

	2016	2017	2018	2019	2020
Халдварт өвчнөөр өвчлөгчид	0	15	21	47	37
Вируст гепатит	0	0	1	0	0
Салхин цэцэг	0	0	1	2	8
Цусан суулга	0	17	0	0	1
Бусад	0	15	19		28

Хөдөө аж ахуй

3.2.3.1 Мал аж ахуй

Баян-Овоо суманд 2019 онд 460 малчин байсан бол 2020 онд энэ тоо өсөж 540 малчин иргэдтэй болсон байна. Мөн 2019 онд 706 малтай өрх байсан бол 2020 онд малтай өрхийн тоо 728 болж өссөн байна.

Түүнчлэн 2019 онд тус сум 272.5 мянган толгой малтай байсан бол 2020 онд 237.18 мянган малтай болсон байна. Нийт малын 45.4% нь ямаа, 47.8 % нь хонь эзэлж байна (Хүснэгт 3-8 Error! Reference source not found.).

Хүснэгт 3-8. Баян-Овоо сумын малын тоо, 2019-2020

	2019	2020
Адуу	9.38	8.16
Үхэр	7.97	7.31
Тэмээ	0.46	0.42
Хонь	135	113.54
Ямаа	119.69	107.76

Үүнээс гадна 2019 онд 104.04 мянган толгой төл бойжуулсан бол 2020 онд 108.08 мянган толгой төл бойжуулсан байна..

Малчин өрхийн амьжиргааны зарим үзүүлэлтүүдийг авч үзвэл 2020 оны байдлаар цахилгааны эх үүсвэр хэрэглэдэг өрх 127, нарны эх үүсвэр хэрэглэдэг өрх 127, бага оврын цахилгаан эх үүсвэртэй 2 өрх, сансарын антентай 87 өрх, телевизортой 87 өрх, радиотой 5 өрх, оёдлын машинтай 44 өрх байна.

Хүснэгт 3-9. Малчин өлхийн зарим үзүүлэлт

	2019	2020
Цахилгааны эх үүсгүүр	363	127
нарны	358	127
Бага оврын цахилгаан үүсгүүр	0	2
Сансрын антен	218	873
Телевизор	319	87
Радио	21	5
Оёдлын машин	189	44

3.2.3.2 Газар тариалан

Баянхонгор аймгийн хэмжээнд 2020 онд үр тариа 9.5 га-д, төмс 253.4 га-д, хүнсний ногоо 144.7 га- д, 344.6 га-д тэжээлийн ургамал тус тус тариалалт хийсэн нь, өмнөх онтой харьцуулахад үр тариа

4.4 хувь буюу 0.4 га-аар, төмс 6.3 хувь буюу 15 га-аар тус тус өсч, хүнсний ногоо 11.7 хувь буюу 19.2 га-аар буурсан байна. Үүнээс Баян-Овоо сумын газар нутагт төмс 24 га-д, тэжээлийн ургамал 32 га- д, хүнсний ногоо 22.02 га-д тариалалт хийсэн байна.